

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2017 ОНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хариуцах газар нэгж, албан тушаалтан
<b>Нэг. Шудрага, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгыг хангах чиглэлээр</b>				
1	4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	3. ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг оруулдаг болох	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2017 онд нийт 21 албан хаагчийн ХАСУМ мэдүүлснээс 20 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу томилсон байна. Хэрэгжих шатанд /-/	ТЗУГ, ЭБАТ
2	4.1.1.2. нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан дэвшүүлэх	6. Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг батлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолоор Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан. Уг тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг Уул уурхайн бодлогын газар, Геологийн бодлогын газар, Түлшний бодлогын газар, Хүнд үйлдвэрийн бодлогын газар /Техник, технологийн хэлтэс, Металл бус үйлдвэрлэлийн хэлтэстэй/, Төрийн захиргааны удирдлагын газар /Хуулийн хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Санхүүгийн хэлтэстэй/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ,	Бүх газар, хэлтэс

			дотоод аудитын газар гэсэн 7 газар, 5 хэлтэст, 78 орон тоотойгоор баталсан. Уг тогтоолын дагуу Төрийн нарийн даргын 2016 оны Б/13 дугаар тушаалаар яамны дотоод нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан. Хэрэгжих шатанд /-/	
3	4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах	1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн цахим системтэй холбогдох нөхцөлийг хангах	Тус яам нь албан хэрэг хөтлөлтийн цахим системд шилжин <a href="https://intranet.gov.mn/">https://intranet.gov.mn/</a> гэсэн Засгийн газрын албан хэрэг хөтлөлтийн программыг үйл ажиллагаандаа хэрэглэн ажиллаж байна. Биелсэн 100%	ТЗУГ
4	4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, Авилгын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 140 дүгээр тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг баталсан. Сургалтын хөтөлбөрөөр Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д заасан албан хаагчийн баталгааг хангах, хүний нөөц бүрдүүлэх, бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоо бий болгох, яам, агентлагийн удирдах болон гүйцэтгэх албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилготой. 2017 онд яамнаас богино хугацааны сургалт, семинарт гадаад, дотоодод давхардсан тоогоор 140 / 30 дотоодод 110/ албан хаагч тус тус хамрагдсан байна. Яамны нийт албан хаагчдад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухай, ХАСХОМ, ХАСУМ-ийн талаар мэдээлэл, мэдлэг олгох сургалтыг	ТЗУГ

			Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай хамтран сургалт зохион байгуулсан. Хэрэгжих шатанд 100%	
<b>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
5	4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бэхжүүлэх	1. Яамны цахим сүлжээнд авилгын эсрэг төлөвлөгөөг байршуулах, санал, сэтгэгдэл хүлээж авах боломжийг бүрдүүлэх	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2017 онд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> сайтад байршуулсан. Иргэд олон нийтээс санал сэтгэгдэл хүлээж авах бүх боломж хангагдсан. Хэрэгжих шатанд 90%	ТЗУГ
6	4.1.2.4. эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/221 дүгээр тушаалаар Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд нэгдсэн хяналт хийх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн удирдамжийн дагуу дараах чиглэлээр хяналт-шинжилгээ хийсэн. <ul style="list-style-type: none"> <li>• Албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлт</li> <li>• Ажлын байрны тодорхойлолт</li> <li>• Газрын даргын А, Б тушаалууд</li> <li>• 2017 оны үр дүнгийн гэрээ, 2017 оны хагас жилийн илтгэх хуудас</li> <li>• Бусад хэлтэс, тасгийн үйл ажиллагаа, бичиг баримт</li> </ul> Ажлын хэсгийн тайланг сайдад танилцуулан санал, зөвлөмж боловсруулан АМГТГ-т хүргүүлсэн. Хэрэгжих шатанд 100%	ТЗУГ, ХШУДАГ

**Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**

7	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	1. Яамны санхүүгийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх	<p>Шилэн дансны тухай хуулийн дагуу УУХҮЯам 2017 онд Шилэн дансны цахим санд 13 төрлийн мэдээллийг жил, улирал, сарын давтамжтайгаар 79 удаа байршуулахаас 75 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хожимдуулж /засвар оруулсан/ байршуулсан ба 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.</p> <p>Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 47 мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягтай холбоотой 67 гүйлгээ, Худалдан авах ажиллагааны тайлантай холбоотой 45 мэдээлэл, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой 19 мэдээлэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 105 мэдээллийг тус тус байршуулсан.</p> <p>Хагас болон бүтэн жилээр байршуулах Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Дараа жилийн төсвийн төсөл, Санхүүгийн тайлан, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хуулийн хугацаанд байршуулсан.</p>	ТЗУГ, СХ
---	--	---	--	----------

			<p>Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд 2 удаа засвар оруулсан, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлд 1 удаа тус тус засвар оруулсан байна.</p> <p>Үндэсний аудитын газраас 2017 онд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар зөрчил илрээгүй болно.</p> <p>Хэрэгжих шатанд 100%</p>	
<b>Зургаа. Авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
8	4.1.6.5. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах	1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлэх	<p>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/99 тоот тушаалаар Уул уурхайн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж уг хуулийн төслийн 12 дугаар бүлгийг бүхэлд нь ил тод байдлыг хангах талаар зохицуулалтыг оруулж өгсөн.</p> <p>Уул уурхайн тухай хууль батлагдснаар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал хангагдах боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм.</p> <p>Хэрэгжих шатанд 30%</p>	Бүх газар, хэлтэс
9		2. Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын алба болон Нээлттэй нийгэм форумын хооронд 2017.06.22-ны өдөр Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн нэгдсэн сан байгуулах замаар эрдэс баялгийн салбар дахь	Бодлогын газрууд, БХЗГ

		гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр Санамж бичиг байгуулсан. Талууд эрдэс баялгийн салбарт байгуулагдсан гэрээг ( <a href="http://www.iltodgereee.mn">www.iltodgereee.mn</a> <a href="http://www.resourcecontracts.mn">www.resourcecontracts.mn</a> цахим санд байршуулж, олон нийтэд ил тод болгох чиглэлээр хамтран ажиллаж байна. Тухайлбал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.12-ны өдрийн А/06 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг эрдэс баялгийн салбарын гэрээнүүдийг ил тод болгох, цахим санд байршуулах ажлыг нэгтгэн зохион байгуулж байна. Хэрэгжих шатанд 30%	
10	4. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тухай хууль, журмын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, заавар, зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулах талаар БОАЖЯ, МХЕГ-тай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд Газрын тос уламжлалт бус газрын тосны эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг боловсруулж байна. Хэрэгжих шатанд 30%	ТБГ, ТЗУГ, ХХ
11	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах	“Олборлох ил тод байдлын санаачилга”-д нэгдэх талаар гэрээлэгч компаниудад зөвлөмжийг өгсөн. 2017 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар Петрочайна Дачин Тамсаг ХХК, Петро Матад ХХК, Сентрал Азиан Петролиум Корпорэйшн Лимитед ХХКомпаниуд уг санаачлагад нэгдээд байна. Газрын тосны хайгуул ашиглалттай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж компаниудын талаарх мэдээллийг	ТБГ

			нэгтгэн Олборлох үйлдвэрлэлийн ажлын алба, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төсөлд хүргүүлэн хамтран ажиллаж байна. Хэрэгжих шатанд 30%	
<b>Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авилгын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
12	4.1.10.1. авилгын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авилгыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	4. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлан, мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2016 оны хэрэгжилтийг гарган хуулийн хугацаанд буюу 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 03/468 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Биелсэн 100%	ТЗУГ, бүх газар хэлтэс
<b>Яамны эрхлэх ажлын хүрээнд</b>				
13	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	Хуулиар болон бусад холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрээр зөвшөөрөгдсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулах	Авлигатай тэмцэх газартай хамтран хуулиар болон холбогдох бусад шийдвэрээр зөвшөөрөгдсөн давхар ажил эрхэлж болох ажил, албан тушаалын талаар мэдээлэл, сургалтыг зохион байгуулсан. Мөн АТГ-аас ирсэн давхар ажил эрхлэлттэй холбоотой зөвлөмж ирүүлснийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Жил бүр судалгааг шинэчилэн хүргүүлнэ. Биелсэн 100%	ТЗУГ, ЭБАТ
14		Давхар ажил эрхэлж байгаа ажилтны судалгааг гаргах	Яамны нийт давхар ажил эрхлэлтийн талаар судалгааг нийт албан хаагчдаас гаргуулан авч АТГ-ын ХШДШХ-ийн холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. <a href="mailto:terbish@iaac.mn">/terbish@iaac.mn</a> , <a href="mailto:enkhtuya@iaac.mn">enkhtuya@iaac.mn</a> , <a href="mailto:batchuluun@iaac.mn">batchuluun@iaac.mn</a> / Биелсэн 100%	ТЗУГ, ЭБАТ

ТАНИЛЦСАН:  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

М.БАЯРАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
ТЗУГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Г.МӨНГӨНЗУЛ